



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

Албан журмын даатгагчдын холбооны
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас Б.Батбаяр, Ц.Цолмон нарыг чөлөөлсүгэй.

2. Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Нямаа, “Монгол даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Батзул нарыг Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр томилсугай.

3. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг Б.Нямаа, Т.Батзул нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000330